



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Сүхбаатар сум

2019 оныг “Бүтээн байгуулалтыг нэмэгдүүлж, өрхийн аж ахуйг хөгжүүлэх жил” болгон зарлаж, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Сэлэнгэ аймгийг Тариалангийн бүс нутаг болгосонтой холбогдуулан өрхийн аж ахуйг хөгжүүлэх, аймгийн 90 жилийн ой, “Атар”-ын 60 жилийн ойг угтан хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудыг эрчимжүүлэх зорилгоор 2019 оныг “Бүтээн байгуулалтыг нэмэгдүүлж, өрхийн аж ахуйг хөгжүүлэх жил” болгон зарласугай.

2. Зарласан жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар идэвх, санаачилгатай үр дүнтэй тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, бүх шатны төр, төсвийн байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг нэгтгэн боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлд хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА Ш.ОРГИЛ